

## ХЯТАДЫН ЭРДЭМТЭД АЙЛЧЛАВ

2009 оны 10 дугаар сарын 27-ноос 30-ны өдрүүдэд Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Ази, Номхон Далайн Судлалын хүрээлэнгийн эрдэмтэд тус хүрээлэнд айлчлав. Айлчлалын хүрээнд энэ жилийн 6 дугаар сард Бээжин хотноо зохиогдсон “Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хурал” дээр хэлэлцсэний дагуу манай хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудтай “Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах” төсөл боловсруулах талаар санал солилцож дугуй ширээний хурал зохион байгуулав.

Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Ази, Номхон Далайн Судлалын хүрээлэнгээс доорхи эрдэмтэн судлаачид хуралд оролцов: АНДСХ-ийн дэд захирал, судлаач Хан Фэн, АНДСХ-ийн бүс нутгийн хамтын ажиллагаа судлалын тэнхимийн эрхлэгч, судлаач Цай Юү, АНДСХ-ийн Зүүн хойд Ази судалгааны төвийн орлогч эрхлэгч, дэд судлаач Чэн Шан, “Өнөөгийн АНД” сэтгүүлийн редактор Жан Дунхай, АНДСХ-ийн бүс нутгийн хамтын ажиллагаа судлалын тэнхим, туслах судлаач Гун Жинжүн, АНДСХ-ийн гадаад харилцааны хэсгийн ажилтан Син Вэй.

Дугуй ширээний хуралд Гадаад Хэргийн Яам, Стратеги судлалын хүрээлэн зэрэг байгууллагуудаас холбогдох мэргэжилтнүүд оролцож харилцан санал солилцов.